




ЗАХИАЛАГЧ:  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭСАЙХАН

ГҮЙЦЭТГЭГЧ:  
“ИТГЭЛ ДҮҮРЭН” БҮЛГИЙН  
АХЛАГЧ Д.ЗОРИГТБОЛД



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН  
“БАГШ НАРЫН БАЙРНЫ ГАДНА ТАЛЫН ЗАСВАР”-ЫН ГЭРЭЭ  
ДУГААР № ДУГАЦДСЗДТГ/202301013

2023.05.15.

Хараат

Нэг талаас (цаашид “Захиалагч” гэх) Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас “Итгэл дүүрэн” бүлгийн ахлагч Д.Зоригтболд (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 15 –ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын “Багш нарын байрны гадна талын засвар”-ын ажил ДУГАЦДСЗДТГ/202301013 дугаартай (цаашид “гэрээний үүрэг” гэх) 19,898,500 (Арван есөн сая найман зуун ерэн найман мянга таван зуу)-н төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь “Багш нарын байрны засвар”-ын ажил 19898500 (Арван есөн сая найман зуун ерэн найман мянга таван зуун) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь тус сумын “Багш нарын байрны гадна талын засвар”-ын ажлыг техникийн тодорхойлолтонд заагдсан нөхцлийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Ажлыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлж 2023 оны 07 дугаар сарын 20 -ны өдрийн дотор гүйцэтгэнэ.
5. Санхүүжилтийг материалаа татаж авчирсны дараа 70%, ажлын гүйцэтгэл дууссаны дараа 30%-ийг ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 6.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт
- 6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь
- 6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

11. Ажлыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.

12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.


### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

..... У.МӨНХ-ЭРДЭНЭ



**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"ИТГЭЛ ДҮҮРЭН" БҮЛГИЙН

ГИШҮҮН

..... Х.ЖАРГАЛСАЙХАН

**ХАЯГ:** Дундговь аймгийн Цагаандэлгэр сум **ХАЯГ:** Дундговь аймаг Цагаандэлгэр сум

Хараат 1-р баг

сумын төв 1-р баг

Утас:89030172

Харилцах данс: ХААН 5463031876

Утас: 88068532